

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА, САНГИЙН САЙДЫН  
ХАМТАРСАН ТУШААЛ

2015 оны 5 дугаар  
сарын 22-ны өдөр

Дугаар 142/119

Улаанбаатар хот

Жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхэлж байгаа  
даатгагчаас жолоочийн даатгалын санд 2015 онд төвлөрүүлэх  
хөрөнгийн хэмжээг тогтоох тухай

Жолоочийн даатгалын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дах хэсгийг  
үндэслэн ТУШААХ нь:

1. Жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий даатгагч бүрээс Жолоочийн даатгалын санд 2015 онд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг даатгагч тус бүрийн 2014 оны жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын орлогод тооцсон хураамжийн дүнгийн 2.5 хувиар тогтоосугай.
2. Дээрх мөнгөн хөрөнгийн 50 хувийг Жолоочийн даатгалын санд 2015 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор, үлдэгдэл 50 хувийг 2015 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн дотор тус тус төвлөрүүлэхийг жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий даатгалын компаниудад үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын алба (Б.Батсэлэнгэ)-нд даалгасугай.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ  
ХОРООНЫ ДАРГА

З.НАРАНТУЯА

САНГИЙН САЙД

Ж.ӨРДӨНЭБАТ